



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

Амралтын өдрийн худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Амралтын өдрийн худалдаа зохион байгуулах тухай” А/496 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бараа бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан сурталчлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, худалдаа, үйлчилгээ чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Амралтын өдрийн худалдаа”-г 2022 оны 05 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Байгаль эх цогцолборт зохион байгуулахыг Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн дарга (Ч.Чойдог)-д үүрэг болгосугай.

2. Дээрх арга хэмжээний хүрээнд хүнсний аюулгүй байдал, бараа бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын хэлтэс (Ц.Идэрбат)-т, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг тухай бүр олон нийтэд түгээн ажиллахыг Хэвлэл мэдээллийн алба (Б.Отгонбаяр)-нд тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуй асуудал хариуцсан төслийн удирдагч (Д.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ө.СУМЪЯАБААТАР

